



**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2014 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

“ЭССЭ” бичлэгийн уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 360 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

Нэг. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2014 оны төлөвлөгөөт ажил, дэлхийн эмч нарын баярын өдрийг тохиолдуулан “Миний мэргэжил-миний бахархал” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулахыг ёс зүйн салбар хороонд даалгасугай.

Хоёр. “ЭССЭ” бичлэгийн уралдааны удирдамжыг хавсралтаар баталж, 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 2014 оны 03 дугаар сарын 19-ний хооронд бүтээлийг хүлээн авч, үр дүнг мэргэшсэн албан тушаалтнуудтай хамтран гарган, шалгарсан “ЭССЭ” бичлэгийг төвийн вэб хуудсанд байршуулан алдаршуулж, дэлхийн эмч нарын баярын өдрөөр шагнаж урамшуулахыг Ёс зүйн салбар хорооны дарга /З.Цэндсүрэн/ болон гишүүдэд даалгасугай.

Гурав. “ЭССЭ” бичлэгийн уралдааныг зохион байгуулах арга хэмжээнд зарцуулах 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийг зохих зардлын сангаас гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

**“МИНИЙ МЭРГЭЖИЛ-МИНИЙ БАХАРХАЛ” СЭДЭВТ
ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Зорилго:

1. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 360 дугаар тушаал, 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 446 дугаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-г шинэчлэн батлах тухай тушаал, СЭМҮТ-ийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2014 оны төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэх
2. Дэлхийн эмч нарын баярын өдрийг угтан Сэтгэцийн эмчийн мэргэжлийн үнэ цэнийг өндөрт өргөх
3. Сэтгэцийн эрүүл мэндийн албаны 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Сэтгэцийн эмчийн мэргэжлийн бахархалыг иргэд, олон нийтэд сурталчлах

Сэдэв: “МИНИЙ МЭРГЭЖИЛ- МИНИЙ БАХАРХАЛ”

Хамрах хугацаа:

2014 оны 03 дугаар сарын 04-нөөс 2014 оны 03 дугаар сарын 19-ны өдрүүдэд

Хамрах хүрээ:

СЭМҮТ-ийн нийт эмч нар

Тавигдах шаардлага:

1. Сэдвийн хүрээнд 1300-1500 үгтэй байх
2. ЭССЭ нь зөвхөн монгол хэлээр бичигдсэн байх
3. ЭССЭ нь А4 хэмжээтэй цаасан дээр зүүн талаас 3 см, баруун талаас 2 см, дээр болон доороосоо 2.0 см зайтай Agial фонтоор, 12 хэмжээстэй үсгээр мөр хооронд 1.5 зайтай бичнэ.
4. Зураг, ном зүйг оролцуулж болно.
5. ЭССЭ-ийн эхэнд бүтээлийн нэр, зохиогчийн нэрийг заавал бичнэ.
6. ЭССЭ-г сайтар нягталж, шалгасан байх ба үг, үсэг, таслал, цэгийн алдаа мадаггүй байна.
7. ЭССЭ-г цаасан дээр хэвлэсэн 1 хувь, flash дискээр эсвэл цахим шуудангаар tsende_kh@yahoo.com хаягаар ирүүлнэ үү.

Дүгнэх комисс:

- ✓ СЭМҮТ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны гишүүд
- ✓ ЭМШУИС-ын СЭМ-ийн тэнхимийн багш

Шагнал, урамшуулал:

- ✓ I байр – 1 /100000 төгрөг, батламж/
- ✓ II байр – 1 /80000 төгрөг, батламж/